

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/25

Арвайхээр

Ажил эрчимжүүлэх тухай

Монгол улсын Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэхь заалт, Засгийн газрын "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай" 2009 оны 5 дугаар сарын 14-ны өдрийн 143 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын цахим хуудасны хөтлөлтийг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын цахим хуудсыг чанаржуулан, үйл ажиллагааны ил тод байдлын мэдээллийг сайжруулж, сар бүр тайлагнаж байхыг Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

3. Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага (MNS 6285:2016) стандартын дагуу мэдээллийг чанартай, өнгө үзэмжтэй, шуурхай бэлтгэн, цаг тухай бүрт оруулж байхыг хэлтэс, албаны дарга нарт даалгасугай

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

ЭМГ-ыг даргын 2020 оны 08 дугаар
сарын 27 өдрийн 42 тушаалын
нэгдүгээр хавсралт

ИЮЕ0007

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч – ХШҮМХ-ийн дарга Я.Жаргал

Гишүүд- Компьютер, программ хангамж хариуцсан мэргэжилтэн Р. Төмөрбаатар

Олон нийттэй харилцах ажилтан П.Цэнгэлбаяр

Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны асуудал

хариуцсан мэргэжилтэн Б. Оюунчимэг

Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн Ц. Сонинбаяр

ЭМГ-ыг даргын 2020 оны 08 дугаар сарын 27 өдрийн тушаалын хоёрдугаар хавсралт



БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ БҮРДЭЛТ, ХӨТЛӨЛТИЙГ
САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах ажилтан
1	Одоо байгаа цахим хуудсанд үнэлгээ хийж, дүгнэлт хийх	8-р сард	П.Цэнгэл баяр
2	Цахим хуудсанд тавигдах шаардлага, ил тод нээлттэй байдлыг сайжруулах хувилбаруудыг судлах	8-р сард	Р.Төмөрбаатар
3	Хамгийн сайн цахим хуудастай байгууллагын туршлагаас судлах	9-р сарын эхний 7 хоногт	Ажлын хэсэг
4	Ажлын хэсгийн төлөөлөлүүдийг вебхуудас чанартай хөтлөх сургалтад хамруулах	9-р сард	Б.Валя П.Оюунбилэг
5	Шинэчилсэн хувилбаруудыг гаргаж, удирдлагын багаар хэлэлцүүлэх	9-р сарын 10	Оюунчимэг
6	Шинэ цахим хуудасны талаар мэргэжилтнүүдэд мэдээлэл өгөх, тавигдах шаардлагыг танилцуулах	9-р сараас	Р.Төмөрбаатар
7	Байгууллагын цахим хуудсанд нэмэлт өөрчлөлтүүдийг хийж тогтмол хөтлөх	9-р сард	Ажлын хэсэг
8	Сар бүр цахим хуудсанд байршуулсан мэдээлүүдэд үнэлгээ дүгнэлт өгч, удирдлагад танилцуулах	Сар бүр	Я.Жаргал
9	Цахим хуудсанд оруулах мэдээллийн агуулга, тавигдах шаардлагыг багтаасан зөвлөмж гаргаж, хэлтсүүдэд хүргэн мэдээлэлд тухай бүр хяналт тавих	Сар бүр	Ажлын хэсэг